



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

**Төрийн захиргааны албан  
хаагчийн тангараг өргүүлэх тухай**

Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйл, Монголын Улсын Ерөнхийлөгчийн “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журмыг батлах тухай” 1995 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 109 дүгээр зарлиг, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам батлах тухай” Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 128 дугаар тогтоолын “Хоёр”-ын 2.1, 2.2, “Төрийн албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай” 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 194 дүгээр тогтоол, Салбар зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу яамнаас 16, Цаг уур орчны шинжилгээний газраас 2, Хан Хэнтийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаанаас 8, Горхи-Тэрэлжийн Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас 1, Туул голын сав газрын захиргаанаас 5, хавсралтад дурдсан нэр бүхий 32 иргэнийг Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 12 цагаас ХААН танхимд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан журмын дагуу зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, холбогдох албан хаагчдад үүрэг болгосугай

САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.БАТЖАРГАЛ